



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын салбарын хүний  
нөөцийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого", Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөр"-ыг хавсралтаар баталсугай.

2. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 1 дүгээр улиралд багтаан сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Биеийн тамир, спортын газар /Ц.Шаравжамц/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын бодлогын газар /С.Чинбат/-д даалгасугай.

  
Ж.БАТСУУРЬ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын 2016 оны 10 дугаар  
сарын 09-ний өдрийн А/НС тоот  
тушаалын хавсралт



## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын үндсэн зорилт нь Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгох, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Хүний эрүүл байх, бие бялдрын өв тэгш хөгжилтэй байх эрхийг хангах, биеийн тамир, спортыг хүний болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр болгон хөгжүүлэх зорилгоор батлагдсан НҮБ-ын 2014 оны "Бие бялдрын боловсрол, спортын харти", НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2013 оны "Берлиний Тунхаглал", Олон Улсын Олимпийн Хорооны "Спортыг бүхний төлөө" зорилтууд батлагдаж гишүүн улс орнуудад дээрх зорилтыг хангах үндэсний тогтолцоо бий болгох, биеийн тамир, спортыг нийгмийн бүхий л салбар, байгууллагыг хамруулан хөгжүүлэхийг зөвлөж байна.

Биеийн тамир, спортын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор иргэдэд бие бялдрын боловсрол олгох, биеийн тамир, спортыг бусад салбар, байгууллагуудад хөгжүүлэх, спортын мэргэжлийн тодорхой чиг үүргийг спортын төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэг салбарт хийгдэх шинэчлэлийг удирдан зохион байгуулах, хүн амын орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадварлаг хүний нөөцийг үе шаттайгаар бэлтгэх, бүрдүүлэх нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа тул энэхүү баримт бичгийг батлаж байна.

Тус бичиг баримт нь "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын хүний нөөцийн хөгжлийн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх салбарын бодлогын баримт бичиг болно.

### Хоёр. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

- 2.1. Хөтөлбөрийн зорилго: Салбарын хэрэгцээ шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын чадварлаг хүний нөөцийг үе шаттайгаар мэргэшүүлэх, мэргэжлийн хувьд өсч, хөгжих, шатлан ажиллах, албан тушаал ахих нөхцлийг бүрдүүлсэн хүний нөөцийн хөгжлийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

## 2.2. Хөтөлбөрийн зорилт:

- 2.2.1. Биеийн тамир, спортын мэргэжлээр их, дээд сургууль төгссөн мэргэжилтнийг мэргэшүүлэх төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх;
- 2.2.2. Мэргэшүүлэх төгсөлтийн дараах сургалтаар удирдлага, арга зүйч болон дасгалжуулагчийн чиглэлээр хөгжих, мэргэшлийн зэрэг, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, мэдлэг ур чадварт нийцсэн албан тушаал эрхлэх, шатлан ахих тогтолцоог бүрдүүлэх;
- 2.2.3. Биеийн тамир, спортын хүний нөөцийн шатлал ахих хөгжилд тулгуурласан ажлын байрны хуваарилалтын зарчмыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх;

## 2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

- 2.3.1. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөрийг 2020 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

**Гурав. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны гол чиглэл**

Нэгдүгээр үе шат: 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо, эрх зүйн орчин бүрдүүлэх, удирдлага, арга зүйчийн болон дасгалжуулагчийн чиглэлээр шатлал бүхий сургалтын хөтөлбөрийг батлуулах ажлыг 2017 оны эхний хагас жилд хэрэгжүүлнэ.
2. Мэргэшлийн зэрэг хангасан ажилтан, арга зүйч, дасгалжуулагчид мэдлэг, ур чадварт тохирох ажил, албан тушаал эрхлэх асуудлыг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
3. Биеийн тамир, спортын бүх шатны төрийн байгууллагад ажиллаж буй мэргэжилтэн, арга зүйч, дасгалжуулагчдын сургалтыг 2017 оны хоёрдугаар хагас жилээс зохион байгуулна.

Хоёрдугаар үе шат: 2018-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Биеийн тамир, спортын салбарын төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн бүх клубын дасгалжуулагчдыг сургалтад хамруулах үйл ажиллагааг 2018 оны нэгдүгээр улирлаас эхлэн төлөвлөгөөний дагуу үе шаттай хэрэгжүүлнэ
3. Биеийн тамир, спортын салбарын төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын бүх төв, клубын арга зүйчдийг сургалтад хамруулах үйл ажиллагааг 2018 оны хоёрдугаар улирлаас эхлэн төлөвлөгөөний дагуу үе шаттай хэрэгжүүлнэ.

4. Биеийн тамир, спортын салбарын төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын бүх төв, клубын менежерүүдийг сургалтад хамруулах үйл ажиллагааг 2018 оны гуравдугаар улирлаас эхлэн төлөвлөгөөний дагуу үе шаттай хэрэгжүүлнэ.

5. Спортын холбоодын менежерүүдийг сургалтад хамруулах үйл ажиллагааг 2019 оноос эхний хагас жилээс үе шаттай хэрэгжүүлнэ.

Гуравдугаар үе шат: 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Мэргэшүүлэх төгсөлтийн дараах сургалтын шинээр бүрдүүлсэн тогтолцооны үйл явцад хяналт шинжилгээ хийж, үнэлгээ гаргана.

2. Хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслэн тогтолцоонд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд урт хугацаанд мөрдөж ажиллана.

#### **Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт:**

4.1. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлын зардал нь биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгагдан улсын төсвөөс санхүүжнэ.

4.2. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын тогтолцооны дагуу сургалт зохион байгуулах зардал нь биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төсөв, сургалтын төлбөрөөс бүрдэнэ.

4.3. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын тогтолцооны дагуу сургалтанд хамрагдах төлбөрийг хувь хүн хариуцна. Шаталсан сургалтанд хамрагдах төлбөрийг бүх шатны биеийн тамир, спортын төсөвт байгууллага хариуцахгүй. Сургалтын төлбөрийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

#### **Тав. Мэргэжилтний хөгжлийн загвар**

5.1. Биеийн тамир, спортын мэргэжилтний ахин дэвших замналыг "мэргэжилтний хөгжлийн загвар" гэнэ.

5.2. Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургууль, коллежид элсэн суралцаж биеийн тамир, спортын дээд боловсрол /бакалавр/ эзэмшсэн хүнийг "Биеийн тамир, спортын мэргэжилтэн" гэнэ.

5.2.1. Биеийн тамир, спортын мэргэжилтний хөгжлийн загвар нь удирдлага, арга зүйч, дасгалжуулагчийн гэсэн 3 чиглэлтэй байх ба шалгуур, нөхцөл хангавал нэг чиглэлээс нөгөө чиглэлд шилжин ажиллах буюу хавсран ажиллах боломжтой байна.

5.2.2. Мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамруулж мэргэшлийн зэрэг олгоно. Мэргэшлийн зэрэг нь оноосон нэртэй байна.

Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь мэргэжилтний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, үнэлэх, баталгаажуулахад чиглэгдэнэ.

### 5.3. Биеийн тамир, спортын удирдлагын хөгжлийн дэд загвар (Схем №1)

5.3.1. Удирдлагын хөгжлийн дэд загварын дагуу сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан биеийн тамир, спортын мэргэжилтэн нь аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад мэргэжилтнээр ажиллаж болно.

5.3.2. Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад мэргэжилтнээр 6 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын хөгжлийн дэд загварын дагуу сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан мэргэжилтэн нь аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад нэгжийн даргаар ажиллаж болно. Энэ болзлыг хангасан биеийн тамир, спортын мэргэжилтэн нь биеийн тамир, спортын төсөвт байгууллага, Засгийн газрын яам, агентлагт мэргэжилтнээр ажиллаж болно.

5.3.3. Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын нэгжийн дарга, биеийн тамир, спортын төсөвт байгууллага, Засгийн газрын яам, агентлагын хэлтэс, албаны даргаар 6 жил ажилласан биеийн тамир, спортын мэргэжилтэн нь удирдлагын хөгжлийн дэд загварын дагуу сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтанд тэнцсэн бол аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын даргаар ажиллаж болно.

5.3.4. Биеийн тамир, спортын төсөвт байгууллага, Засгийн газрын яам, агентлагт мэргэжилтэнээр 6 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын хөгжлийн дэд загварын дагуу сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан биеийн тамир, спортын мэргэжилтэн нь Биеийн тамир, спортын төсөвт байгууллага, Засгийн газрын яам, агентлагын алба, хэлтэс, газрын даргаар ажиллаж болно.

5.3.5. Засгийн газрын яам, агентлагын нэгжийн даргаар 4 ба түүнээс дээш жил ажилласан, удирдлагын хөгжлийн дэд загварын дагуу сургалтад хамрагдсан, ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтанд тэнцсэн биеийн тамир, спортын мэргэжилтэн нь Засгийн газрын агентлаг, яамны газрын даргаар ажиллаж болно.

### 5.4. Арга зүйчийн хөгжлийн дэд загвар (Схем №2)

5.4.1. биеийн тамир, спортын их, дээд сургууль төгссөн биеийн тамир, спортын мэргэжилтэн нь 2 жилийн хугацаанд арга зүйчээр сум, баг, хороо, байгууллагад ажиллаж болно.

5.4.2. Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн чиглэлээр ажиллах биеийн тамир, спортын мэргэжилтэн нь удирдлагын чиглэлээр ажиллах бол тухай чиглэлийн хөгжлийн дэд загварт тавигдсан шаардлагыг хангаж шатлан ажиллах, албан тушаал ахиж болно.

5.4.3. Биеийн тамир, спортын мэргэжилтэн нь 2 жилээс дээш хугацаагаар биеийн тамирын арга зүйчээр сум, баг, хороо, байгууллагад ажиллах бол арга зүйчийн

хөгжлийн дэд загварын дагуу мэргэшүүлэх сургалтанд давтан хамрагдаж, шалгалтанд тэнцэн арга зүйчийн анхан шатны зэрэг авч ажиллана. Арга зүйчийн анхан шатны зэргийн хүчинтэй хугацаа нь 4 жил байж болно.

5.4.4. Анхан шатны зэрэгтэй арга зүйч сум, баг, хороо, байгууллагад 4 жил ажиллаж, цаашид үргэлжлүүлэн ажиллах бол анхан шатны мэргэшүүлэх сургалтанд давтан хамрагдаж, шалгалтанд тэнцэн мэргэшлийн зэргээ давтан баталгаажуулж ажиллана. Давтан авсан анхан шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

5.4.5. Анхан шатны зэрэг авсан биеийн тамирын арга зүйч нь 4 жилийн хугацаанд нийтийн биеийн тамирын арга зүйчээр сум, баг, хороо, байгууллагад ажилласан ажлын үзүүлэлтээр зэрэг ахих эрх үүснэ. Арга зүйчийн хөгжлийн дэд загварын дагуу 2 дахь шатлалын сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн хоёрдугаар шатны зэргийг зэрэг авч ажиллана. Хоёрдугаар шатны зэргийн хүчинтэй хугацаа 4 жил байж болно. Хоёрдугаар шатны зэрэгтэй биеийн тамирын арга зүйч нь аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж болно.

5.4.6. Хоёрдугаар шатны зэрэгтэй биеийн тамирын арга зүйч нь аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад 4-өөс дээш жилийн хугацаагаар үргэлжлүүлэн ажиллах бол хоёрдугаар шатны зэргийн сургалтанд давтан хамрагдан, шалгалтанд тэнцэн мэргэшлийн зэргээ давтан авна. Давтан авсан хоёрдугаар шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

5.4.7. Хоёрдугаар шатны зэрэгтэй биеийн тамирын арга зүйч 4 жил ажилласан ажлын үзүүлэлтээр зэрэглэл ахих эрх үүснэ. Арга зүйчийн хөгжлийн дэд загварын дагуу 3 дахь шатлалын сургалтанд тодорхой хугацаанд хамрагдан, шалгалтанд тэнцэн гуравдугаар шатны зэрэг авна. Гуравдугаар шатны зэргийн хүчинтэй хугацаа 4 жил байж болно. Гуравдугаар шатны зэрэгтэй биеийн тамирын арга зүйч нь ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэн бол аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад нэгжийн даргаар ажиллаж болно.

5.4.8. Гуравдугаар шатны зэрэгтэй биеийн тамирын арга зүйч нь аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагад нэгжийн даргаар 4 жилээс дээш хугацаагаар үргэлжлүүлэн ажиллах бол гуравдугаар шатны зэргийн сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн мэргэшлийн зэрэг давтан авна. Давтан авсан гуравдугаар шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

## 5.5. Дасгалжуулагчийн хөгжлийн дэд загвар (Схем №3)

5.5.1. Шинэ төгссөн биеийн тамир, спортын мэргэжилтэн нь 2 жилийн хугацаанд орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага, клуб, дугуйлан зэрэгт спортын анхан шатны сургалтын үйл ажиллагаа эрхэлж болно.

5.5.2. Дасгалжуулалтын чиглэлээр шинэ төгссөн биеийн тамир, спортын мэргэжилтэн нь удирдлагын чиглэлээр ажиллах бол тухай чиглэлийн хөгжлийн дэд загварт тавигдсан шаардлагыг хангаж шатлан ажиллах, албан тушаал ахиж болно.

5.5.3. Шинэ төгссөн биеийн тамир, спортын мэргэжилтэн нь 2 жилээс дээш хугацаагаар орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага, клуб, дугуйлан

зэрэгт дасгалжуулагчаар ажиллах бол дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд тодорхой хугацаанд хамрагдан, шалгалтанд тэнцэн зэрэг авч ажиллана. Анхан шатны зэргийн хүчинтэй хугацаа нь 4 жил байж болно.

5.5.4. Анхан шатны зэрэгтэй дасгалжуулагч 4 жилээс дээш хугацаагаар спортын анхан шатны сургалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхлэх бол анхан шатны зэргийн сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн мэргэшлийн зэргээ давтан авч ажиллана. Давтан авсан анхан шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

5.5.5. Анхан шатны зэрэгтэй дасгалжуулагч нь спортын анхан шатны сургалтын үйл ажиллагааг 4 жил эрхэлж, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд дасгалжуулсан баг тамирчид нь тогтмол амжилттай оролцсоноор зэрэг ахих эрх үүснэ. Зэрэг ахих эрх үүсэх амжилтыг спортын холбоод тогтооно.

5.5.6. Зэрэг ахих эрх үүссэн дасгалжуулагч дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд тодорхой хугацаанд хамрагдан, шалгалтанд тэнцэн хоёрдугаар шатны зэрэг авч ажиллана. Хоёрдугаар шатны зэргийн хүчинтэй хугацаа нь 4 жил байж болно. Хоёрдугаар шатны зэрэгтэй дасгалжуулагч нь өсвөрийн шигшээ багт дасгалжуулагчаар ажиллаж болно.

5.5.7. Хоёрдугаар шатны зэрэгтэй дасгалжуулагч 4 жилээс дээш хугацаагаар өсвөрийн шигшээ багт дасгалжуулагчаар үргэлжлүүлэн ажиллах бол хоёрдугаар шатны зэргийн сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн мэргэшлийн зэргээ дахин авч ажиллана. Давтан авсан хоёрдугаар шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

5.5.8. Өсвөрийн шигшээ багт дасгалжуулагчаар 4 жил ажилласан хоёрдугаар шатны зэрэгтэй дасгалжуулагчийн улсын аварга шалгаруулах тэмцээнд үзүүлсэн амжилт, ажлын үзүүлэлт харгалзан зэрэг ахих сургалтанд хамрагдах эрх үүснэ. Зэрэг ахих эрх үүсэх амжилтыг спортын холбоод тогтооно.

5.5.9. Зэрэг ахих эрх үүссэн дасгалжуулагч дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд тодорхой хугацаанд хамрагдан, шалгалтанд тэнцэн гуравдугаар шатны зэрэг авч ажиллана. Гуравдугаар шатны зэргийн хүчинтэй хугацаа нь 4 жил байж болно. Гуравдугаар шатны зэрэгтэй дасгалжуулагч нь залуучууд, оюутны шигшээ багт дасгалжуулагчаар ажиллаж болно.

5.5.10. Гуравдугаар шатны зэрэгтэй дасгалжуулагч 4 жилээс дээш хугацаагаар залуучууд, оюутны шигшээ багт дасгалжуулагчаар үргэлжлүүлэн ажиллах бол дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн гуравдугаар шатны зэргээ давтан авч ажиллана. Давтан авсан гуравдугаар шатны зэрэг нь 6 жилийн хугацаатай байж болно.

5.5.11. Залуучууд, оюутны шигшээ багт дасгалжуулагчаар 4 жил ажилласан гуравдугаар шатны дасгалжуулагчийн тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд үзүүлсэн амжилт, ажлын үзүүлэлт харгалзан зэрэг ахих эрх үүснэ. Зэрэг ахих эрх үүсэх амжилтыг спортын холбоод тогтооно.

5.5.12. Зэрэг ахих эрх үүссэн дасгалжуулагч дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд тодорхой хугацаанд хамрагдан, шалгалтанд тэнцэн дөрөвдүгээр шатны зэрэг авч ажиллана. Дөрөвдүгээр шатны зэргийн хүчинтэй

хугацаа нь 5 жил байж болно. Дөрөвдүгээр шатны зэрэгтэй дасгалжуулагч нь насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багт дасгалжуулагчаар ажиллаж болно.

5.5.13. Дөрөвдүгээр шатны зэрэгтэй дасгалжуулагч 5 жилээс дээш хугацаагаар насанд хүрэгчдийн шигшээ багт дасгалжуулагчаар үргэлжилүүлэн ажиллах бол дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварын дагуу сургалтанд хамрагдан, шалгалтанд тэнцэн зэргээ давтан авч ажиллана. Давтан авсан дөрөвдүгээр шатны зэрэг нь 5 жилийн хугацаатай байна.

5.5.14. Насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багт 4 жилээс дээш хугацаагаар гэрээгээр ажилласан тамирчинд оюутан, залуучуудын шигшээ баг болон насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багт дасгалжуулагчаар шууд шилжин 2 жил ажиллах түр эрх олгож болно. Ийнхүү тамирчнаас дасгалжуулагчийн ажилд шилжсэн насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн тамирчин ажиллах хугацаандаа биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургууль, коллежид элсэн суралцаж, биеийн тамир, спортын дээд боловсрол /бакалавр/ эзэмшиж, цаашид хүний нөөцийн хөтөлбөрийн дагуу шатлан ажиллах, албан тушаал ахина.

#### **Зургаа. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

6.1. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хүний нөөцийн хөгжлийн тогтолцоо, хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлно.


6.2. Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хангана.

6.3. Дасгалжуулагчийн хөгжлийн дэд загварыг баримтлан тухайн спортын төрлийн онцлогыг харгалзсан загварыг спортын холбоод боловсруулж болно.


---oOo---



## УДИРДЛАГЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАР /Схем 1/



## АРГА ЗҮЙЧИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАР /Схем 2/




## ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАР /Схем 3/

### ШАТЛАН АЖИЛЛАХ



### ТОГТВОРТОЙ АЖИЛЛАХ



БТС-ын мэргэжилтэн "Үргэлжлэн чиглэл"-ээр хөгжих бол үргэлжлэн хөгжлийн ажвартын дагуу явдана.

БТС-ын мэргэжилтэн "Боловсролын чиглэл"-ээр хөгжих бол Боловсролын хөгжлийн ажвартын дагуу явдана.

Биеийн тамир, спортын их дээд сургууль, коллеж төгссөн биеийн тамир, спортын мэргэжилтэн  
4 жил буюу 120 багц цаг суралдсан байх